



ГААЛИЙН ГАЗАР, ХОРООДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их тойруу 81/1, Утас: 35 00 54, Факс: (976-11) 35 00 60,  
E-mail: gaali@customs.pmis.gov.mn,  
http://www.customs.pmis.gov.mn

2016.12.28 № 02-1/1834

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Экспортын бараанд хяналт тавих тухай**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.5, 4.6-д заасны дагуу Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалтыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталж, тухайн бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байхаар хуульчилжээ.

Худалдаа аж, үйлдвэрийн танхимын тухай хуулийн хоёдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т “энэ хуульд өөрөөр заагаагүй бол экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх”, 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжих бараа бол түүний гарал үүслийг биржийн тодорхойлолтыг үндэслэн гэрчилнэ” гэж тус тус заасан.


Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө”, 60.3.5-д “Монгол улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг” гэж заасан байдаг.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” А/135 тоот тушаалаар хүнсний буудай болон тосны ургамал /рапс/-ыг Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалтад нэмж оруулан, бараа түүхий эдийн ангиллын кодыг баталснаар Хөдөө аж ахуйн биржээр 2013 онд 14,9 мянган тн, 2014 онд 12,5 мянган тн тосны ургамал тус тус арилжаалсан боловч сүүлийн 2 жилд тосны ургамлыг биржээр арилжаагүй байна.

Иймд дээрх хуулийн заалтууд болон эрх зүйн баримтыг үндэслэн тосны ургамал /рапс/-ын экспортын бүрдүүлэлтийн үед Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас олгосон гарал үүслийн гэрчилгээг бүрдүүлэлтийн нотлох баримт болгохдоо хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолтыг үндэслэсэн эсэхэд хяналт тавьж ажиллахыг анхааруулья.

Хувийг: Хөдөө аж ахуйн бирж ХХК-д

ГААЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



Э.МӨНХӨӨ

0002680